



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН ТҮВШИНД БОЛОВСРУУЛСАН БАЙНА

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ӨГӨХ

АУДИТЫН КОД: АРА-2025/07/01-ШТА-НА

Архангай аймаг 2025 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ
Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn
Ахлах аудитор П.Цэцэгдулам
Цахим хаяг: Tsetsegdulamp@audit.gov.mn
Аудитор Б.Анхтуяа
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn



<p>Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
<p>Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Аудитын менежер Д.Нэргүйбаатар Ахлах аудитор Н.Алтантуяа П.Цэцэгдулам Г.Цог-Эрдэнэ Аудитор Н.Энхчимэг Л.Соёлмөнх В.Цогжаргал Б.Анхтуяа А.Пүрэвцэцэг Н.Дашмягмар Э.Нямсүрэн</p> <p>2025 оны 11 дүгээр сар Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033-3141 дугаарын факсаар харилцана уу</p> <p>Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум 2-р баг: Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар</p>	<p>БҮЛЭГ 1 ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ БОГИНО БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН БАЙНА</p> <p>БҮЛЭГ 2 ТӨСВИЙН ОРЛОГЫГ САНГИЙН ЯАМНААС 6.3 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ХЯНАСАН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА</p> <p>БҮЛЭГ 3 ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН ТҮВШИНД ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫГ 423.4 САЯ ТӨГРӨГӨӨР ХЭМНЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА</p> <p>БҮЛЭГ 4 ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 32 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА</p> <p>БҮЛЭГ 5 ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ САНГИЙН САЙДЫН 2012 ОНЫ 244 ДҮГЭЭР ТУШААЛЫН ДАГУУ БОЛОВСРУУЛСАН БАЙНА</p> <p>ДҮГНЭЛТ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</p> <p>Хүснэгт №1 Аймгийн 2025 оны нийт орлогын ба тусламжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл Хүснэгт №2 Орон нутгийн 2026 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл Хүснэгт №3 Төсвийн төслийн иж бүрдлийн нийцэл Хүснэгт №4 Орон нутгийн суурь орлогын харьцуулсан судалгаа Хүснэгт №5 Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа Хүснэгт №6 Татварын болон татварын бус орлого Хүснэгт №7 Арилжааны банкин дахь хадгаламжийн үлдэгдэл Хүснэгт №8 Сангийн яамнаас хянасан дүн , 2024-2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл Хүснэгт №9 Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох ХХОАТ-ын тооцоолол Хүснэгт №10 Орлогын төлөвлөгөө , гүйцэтгэл /2022-2025 он/ Хүснэгт №11 Орлогын санал, аудитын санал Хүснэгт №12 Нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл Хүснэгт №13 Аудитаар орлого нэмэгдүүлэх санал Хүснэгт №14 Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл Хүснэгт №15 Аудитаар орлого нэмэгдүүлэх санал Хүснэгт №16 Архангай үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын ашгийн тооцоолол Хүснэгт №17 Тунгалаг тамир цогцолбор ОНӨААТҮГ-ын ашгийн тооцоолол Хүснэгт №18 Төсвийн төслийн харьцуулалтын судалгаа Хүснэгт №19 Төсвийн төслийн зохицуулалтын судалгаа Хүснэгт №20 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зарлагын судалгаа Хүснэгт №21 Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад олгох тогтмол зардлын судалгаа Хүснэгт №22 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө Хүснэгт №23 Хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ Хүснэгт №24 Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл Хүснэгт №25 Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл Хүснэгт №26 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт салбараар 3 жилийн байдлаар Хүснэгт №27 ТЭЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, зарцуулах төсөв Хүснэгт №28 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт Дүрслэлийн товьёг 1 Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг (сүүлийн 3 жилээр) Дүрслэлийн товьёг 2 Орон нутгийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь Дүрслэлийн товьёг 3 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй TAX /2025, 2026 он/</p>



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт</i>
МУ	<i>Монгол Улс</i>
УИХ	<i>Улсын Их Хурал</i>
ЗГ	<i>Засгийн газар</i>
ИТХ	<i>Иргэдийн төлөөлөгчдийн хурал</i>
ТЕЗ	<i>Төсвийн ерөнхийлөн захирагч</i>
ЗДТГ	<i>Засаг даргын тамгын газар</i>
СТСХ	<i>Санхүү төрийн сангийн хэлтэс</i>
БОНХОБТХ	<i>Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс</i>
БОХГ	<i>Байгаль орчныг хамгаалах газар</i>
ОНӨГ	<i>Орон нутгийн өмчийн газар</i>
СХДАА	<i>Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба</i>
ГХБХБГ	<i>Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар</i>
ХТҮГ	<i>Хот тохижилт үйлчилгээний газар</i>
ХААГ	<i>Худалдан авах ажиллагааны газар</i>
ОНХС	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
ОНТХО	<i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт</i>
ТАХ	<i>Төсөл арга хэмжээ</i>
ХХОАТ	<i>Хувь хүний орлогын албан татвар</i>
ХБГ	<i>Хүлээгдэж буй гүйцэтгэл</i>
ТЭЗҮ	<i>Техник эдийн засгийн үндэслэл</i>
ОНӨААТҮГ	<i>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар</i>
ГХУСЗ	<i>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал</i>
ЗДНХ	<i>Засаг даргын нөөц хөрөнгө</i>
ЭХЯ	<i>Эрчим хүчний яам</i>
ЭМТ	<i>Эрүүл мэндийн төв</i>



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 05 дугаар тогтоол, Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитын ерөнхий зарчим, зорилго, хамрах хүрээ, арга хандлага, шалгах зүйл, шалгуур үзүүлэлтийг стандартад нийцсэн, хараат бус байдлыг хангасан үр нөлөө бүхий дүгнэлт, зөвлөмж гаргахыг зорьж ажиллалаа. Архангай аймгийн 2026 оны орон төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргахад аудитын зорилго чиглэгдлээ. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх;
- Орон нутгийн 2026 оны төсвийн орлогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу иж бүрэн бодитой тооцож төлөвлөсөн эсэх;
- Орон нутгийн 2026 оны төсвийн зарлагыг хууль тогтоомжид заасны дагуу иж бүрэн, бодитой тооцож төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай хэрэгжүүлэхээр тусгасан эсэх;
- Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнг бодитой, оновчтой тооцож төлөвлөсөн эсэх;

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Төрийн аудитын тулгуур зарчим, MNS 6817 -5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал” 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг гол шалгуур болголоо.



Аудитын хамарсан хүрээ

Аудитын явцад Архангай аймгийн 2025 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2026 оны жилийн төсвийн санал, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, БОХГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа, өмнөх онуудын аудитын тайлан, аймгийн ИТХ-д хүргүүлсэн санал дүгнэлт зэрэгт үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийв.

Талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Аймгийн Засаг дарга нь жилийн төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга,... тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн Орон нутгийн төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын 7.4-т “Аймаг, нийслэлийн аудитор жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Алтантуяа, П.Цэцэгдулам, Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Л.Соёлмөнх, В.Цогжаргал, Б.Анхтуяа, А.Пүрэвцэцэг, Н.Дашмягмар, Э.Нямсүрэн нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл 2025 оны 10 дугаар сарын байдлаар 108.6% буюу 28,116.5 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар буюу 2,755.8 сая төгрөгөөр нэмэгдсэн, орон нутгийн төсвийн зарлага 78.4% буюу 61,777.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нь өмнөх оны мөн үеэс 9.3 хувиар буюу 5,244.0 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна./Аймгийн нийгэм эдийн засгийн байдал статистик эмхэтгэл -2025.10 сар /

Аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн орлогын төлөвлөгөө 2025 оны 10 дугаар сарын байдлаар 53,791.4 сая төгрөг төвлөрөхөөс 58,456.3 сая төгрөг төвлөрч, 4,664.9 сая төгрөгөөр буюу 8.7 хувиар давж биелжээ.


Хүснэгт№1. Аймгийн 2025 оны нийт орлого ба тусламжийн орлого төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хэрэгжилтийн хувь
1	Татварын орлого	20,834.4	24,556.2	3,721.8	117.9
2	Татварын бус орлого	1,967.2	3,531.2	1,564.0	179.5
3	Хөрөнгийн орлого	15.0	28.8	13.8	192.0
4	Бусад орлого /Санхүүгийн дэмжлэг/	30,974.8	30,340.1	(634.7)	98.0
	Нийт орлого	53,791.4	58,456.3	4,664.9	108.7

Орон нутгийн 2026 оны төсвийн төслийн тооцооллыг Сангийн яамнаас Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн удирдамжийн дагуу бэлтгэн онлайнд суурилсан FISCAL-B системд зардлын эдийн засгийн ангилал, зориулалт, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр оруулж, судалгааны хамт Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлжээ. Төсвийн саналд суурь орлогыг 25,678.8 сая төгрөгөөр төлөвлөснийг Сангийн яамнаас 6.3 хувиар нэмэгдүүлэн 27,333.4 сая төгрөгөөр, суурь зарлагыг 87,580.6 сая төгрөгөөр төлөвлөснийг төсвийн зарлагын хязгаар 59,299.6 сая төгрөгт багтаан 35.3 хувиар бууруулан 56,717.8 сая төгрөгөөр хянасан байна.

Монгол Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн тухай хуулиар Архангай аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 32,646.8 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 9,414.2 сая төгрөгөөр тусгасан бөгөөд УИХ-аас 2025 оны 11 дүгээр сарын 12-нд баталсан 2026 оны төсвийн тухай хуулиар Архангай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг өргөн мэдүүлснээс 10.0 хувиар буюу 3,262.3 сая төгрөгөөр бууруулж, 29,384.5 сая төгрөгөөр, харин ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хэвээр баталжээ. Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг өмнөх онуудтай харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Дүрслэл № 1 Санхүүгийн дэмжлэг, ОНХС-ийн шилжүүлэг (сүүлийн 3 жилээр)



Санхүүгийн дэмжлэгийг 2024 онтой харьцуулахад 13.1 хувиар, 2025 онтой харьцуулахад 13.3 хувиар, ОНХС-ийн шилжүүлгийг 2024 онтой харьцуулахад 25.8 хувиар, 2025 онтой харьцуулахад 2.9 хувиар тус тус буурсан байна.

Аймгийн ИТХ-аар батлагдах 2026 оны орон нутгийн төсвийн тэнцэл 67,017.0 сая



төгрөг байна.

Хүснэгт №2. Орон нутгийн 2025 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл

/сая төгрөг/

	2025 он /анх/	2025 он /тод/	2026 он /анх/	Зөрүү
А	1	2	3	4=2-3
Орон нутгийн нийт орлогын дүн	89,213.0	73,938.9	67,017.0	(6,921.9)
Орон нутгийн орлого	26,844.1	26,599.5	28,027.3	1,427.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	11.0	11.0	11.0	-
Санхүүгийн дэмжлэг	46,462.2	33,894.7	29,384.5	(4,510.2)
Урьд оны төсвийн үлдэгдлээс /мал хамгаалах сан, цэргийн дүйцүүлэх алба/	140.0	200.0	180.0	(20.0)
ОНХС-ийн шилжүүлэг	14,505.7	9,698.4	9,414.2	(284.2)
Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдэл	900.0	2,896.0	-	(2,896.0)
ОНХС-ийн урьд оны үлдэгдэл	350.0	639.3	-	(639.3)
Орон нутгийн нийт зарлагын дүн	89,213.0	73,938.9	67,017.0	(6,921.9)
Сумын удирдлагын салбарын дүн	26,183.2	23,639.0	24,271.7	632.7
Аймгийн удирдлагын салбарын дүн	23,469.0	20,723.6	15,105.9	(5,617.7)
Халамжийн сангийн дүн	136.4	136.1	119.3	(16.8)
ОНХС-д зарцуулах	15,531.4	11,013.5	10,101.1	(912.4)
Орон нутгийн байгууллагын тогтмол зардал / Боловсрол, соёл, эрүүл мэнд /	19,076.8	15,031.4	14,429.1	(602.3)
Их засвар	4,736.2	3,315.3	2,909.9	(405.4)
Мал хамгаалах сан	80.0	80.0	80.0	-

Нийт орлогын 41.9 хувь орон нутгийн төсвийн орлого, 43.8 хувь санхүүгийн дэмжлэг, 14.0 хувь нь ОНХС-ийн орлогын шилжүүлэг, урьд оны үлдэгдлээс 0.3 хувь санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн 2026 оны нийт зарлагыг 2025 онтой харьцуулахад 9.4 хувиар буурч төлөвлөгджээ.

Аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн төсөлд өгөх орон нутгийн төсвийн орлого, зардал, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг дараах бүлгүүдэд тусган танилцуулж байна.



БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ БОГИНО БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН БАЙНА

1.1 Аймаг хөгжүүлэх 2026-2030 оны таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулж байна.

Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 зорилго 24 зорилт 55 дэд зорилттой, 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 07/33 дугаар тогтоолоор “Архангай аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-г 4 зорилго 12 зорилт 38 дэд зорилттойгоор баталсан байна. Энэ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй нийцэж байна.

Аймгийн ТЕЗ-аас ирүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан боловсруулсан байна. Харин аймаг хөгжүүлэх 2026-2030 оны таван жилийн үндсэн чиглэл боловсруулалтын шатанд байгаа тул уялдуулан үзэх боломжгүй байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн орлого, зарлагын тухайд:

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт 25 нэр төрлийн орлогыг 28,027.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс татварын орлого 25,953.8 сая төгрөг, татварын бус орлого 2,073.5 сая төгрөг байна. Төсөвт байгууллагын өөрийн орлогыг 11.0 сая төгрөгөөр, ТЕЗ-ийн улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 29,384.5 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 9,414.2 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 180.0 сая төгрөгөөр тус төлөвлөсөн байна.

Төсвийн төсөлд 2026 оны төсвийн жилд зарцуулах нийт хэмжээг 67,017.0 сая төгрөг үүнээс 24,271.7 сая төгрөг нь сумын удирдлагын салбарын зардал, 15,105.9 сая төгрөг нь аймгийн удирдлагын салбарын зардал, 119.3 сая төгрөг нь халамжийн сангийн төсөв, 10,101.1 сая төгрөг нь ОНХС, 14,429.1 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудын барилга ашиглалтын зардал, 2,909.9 сая төгрөг нь их засварын зардал, 80.0 сая төгрөгийг мал хамгаалах санд зарцуулахаар төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалтын зардлын тухайд:

Орон нутгийн 2026 оны төсвийн жилд төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 25 төсөл арга хэмжээнд 8,545.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: 1,427.0 сая төгрөгийн 2 ажлыг орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр, 4,208.7 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, 2,909.9 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

Хөтөлбөр арга хэмжээний тухайд:

“Алсын хараа-2050” болон аймгийн дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хүний хөгжил, эдийн засаг, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр



хэрэгжүүлэх зардлаас 23 арга хэмжээнд нийт 1,451.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

- МУЗГ-ын 2025 оны 158 дугаар тогтоолоор 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбоотой боловсролын салбарт Багшийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 494.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад 296.0 сая төгрөг,
- Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд 50.0 сая төгрөг,
- Нийгмийн хамгааллын салбарт 85.0 сая төгрөг
- Байгаль орчны салбарт 30.0 сая төгрөг,
- Соёл урлагийн салбарт 33.3 сая төгрөг,
- Аялал жуулчлалын салбарт 114.5 сая төгрөг,
- Хүний нөөцийн бодлого, санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулахад 264.9 сая төгрөг,
- Бусад арга хэмжээнд 83.3 сая төгрөг,

1.2. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг хуульд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэсэн байна

Сангийн яамнаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 01/10180 тоот албан бичгээр орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулуулах чиглэлийн дагуу орон нутгийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 67.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2021 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын дагуу боловсруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3. Төсвийн төслийн иж бүрдлийн нийцэл

Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын заалт	Нийцсэн эсэх
7.1.1. үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх;	тийм
7.1.2. төсвийн тэнцэл алдагдалгүй байх;	тийм
7.1.3. хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;	тийм
7.1.4. эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;	тийм
7.1.5. худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.	тийм
7.5.1.а/ аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр;	тийм
7.5.1.б/ төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлогын хэмжээ, харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээгээр.	тийм
7.5.3.а/ аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр;	тийм
7.5.3.б/ аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг сум, дүүрэг тус бүрээр;	тийм
7.5.3.в/ аймаг, нийслэлийн төсөвт сум, дүүргийн төсвөөс татан төвлөрүүлэх орлогын хэмжээг сум, дүүрэг тус бүрээр;	тийм
7.5.3.г/ аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг зориулалтын чиг үүрэг, сум, дүүрэг тус бүрээр;	тийм
7.5.6.а/ төсвийн захирагчийн нэр;	тийм
7.5.6.б/ хөтөлбөрийн нэр;	тийм
7.5.6.в/ тухайн жилд хүрэх чанарын үзүүлэлт;	тийм
7.5.6.д/ зарцуулах төсөв.	тийм
7.5.7.а/ төсвийн захирагчийн нэр;	тийм
7.5.7.б/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр;	тийм



7.5.7.в/ байршил;	Тийм
7.5.7.г/ хүчин чадал;	Тийм
7.5.7.д/ хэрэгжүүлэх хугацаа;	Тийм
7.5.7.е/ төсөвт өртөг;	Тийм
7.5.7.ё/ санхүүжүүлэх эх үүсвэр;	Тийм
7.5.7.ж/ тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн.	Тийм

Төсвийн тухай хуулийн 67.3-т “Энэ хуулийн 67.1-д заасан төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга болон хот, тосгоны Захирагч олон нийтэд танилцуулж, тухайн засаг захиргааны нэгжид амьдарч байгаа иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд танилцуулна” гэсэн заалт нь 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН ОРЛОГЫГ САНГИЙН ЯАМНААС 6.3 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЖ ХЯНАСАН БӨГӨӨД ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

2.1. Орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжид заасны дагуу бэлтгэсэн байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийг боловсруулах удирдамжид заасан хавсралтын дагуу орлогын эдийн засгийн ангиллаар татварын 20, татварын бус 6 нэр төрлийн хүрээнд нийт 25,678.9 сая төгрөгөөр төлөвлөжээ. Энэ нь өмнөх оноос 30.0 буюу 5,927.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4 Орон нутгийн суурь орлого харьцуулсан судалгаа

/сая төгрөг/

ДД	Үзүүлэлтийн нэр	Орон нутгаас хүргүүлсэн 2025 оны суурь орлогын санал	Сангийн Яам хянасан /2025 он/	Сангийн Яам хянасан /2025 он тодотгол/	Орон нутгаас хүргүүлсэн 2026 оны суурь орлогын санал	Сангийн Яам хянасан /2026 он /	Зөрүү
1	АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БҮГД	19,751.0	26,171.4	25,926.8	25,678.8	27,333.4	5,927.8
1.1.	ТАТВАРЫН ОРЛОГО	18,141.8	24,129.0	23,884.4	24,011.9	25,256.9	5,870.1
1.2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,609.2	2,042.4	2,042.4	1,666.9	2,076.5	57.7

Орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогын 92.6 хувийг татварын орлого татварын бус орлого 7.4 хувийг эзэлж байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Эрдэнэбулган сум орон нутгийн төсвийн орлогыг 13,854.4 сая төгрөг, суурь зарлага 5,469.7 сая төгрөгөөр төлөвлөж, зөрүү буюу үндсэн тэнцлийн ашиг 8,384.7 сая төгрөгийг сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогоор тооцсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ”, 56.2.2-т “Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас их тохиолдолд суурь зарлагатай тэнцэх хэсгийн ... 70 хувийг ...тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Орон нутгийн 2026 оны төсвийн орлогыг өмнөх оны суурь судалгаа тооцоолол, 2025



онд төлөвлөлтөд үндэслэн төлөвлөсөн байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам зааврын хүрээнд орон нутгийн орлогын төсвийн төслийг боловсруулахдаа сумдаас ирүүлсэн төсвийн төсөл, мэргэжлийн байгууллагууд, газар хэлтсүүдээс ирүүлсэн холбогдох тооцоо судалгааг нэгтгэж, орон нутгийн төсвийн суурь орлогыг 25,678.9 сая төгрөгөөр боловсруулан Сангийн яаманд хүргүүлжээ.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу татварын 20 нэр төрлийн орлого 24,012.0 сая төгрөг, татварын бус 6 нэр төрлийн орлого 1,646.6 сая төгрөг, нийт 26 нэр төрлийн орлогын хүрээнд орон нутгийн суурь орлогыг төлөвлөсөн байна. Сангийн яамнаас суурь орлогыг 1,654.6 сая төгрөг, нийт орлогыг 1,659.5 сая төгрөгөөр буюу 8 нэр төрлийн орлогыг 10-87.6 хувиар нэмэгдүүлэн хянасан байна. Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №5 Орон нутгийн орлогын харьцуулсан судалгаа

/сая төгрөг/

ДД	Үзүүлэлтийн нэр	Орон нутгаас хүргүүлсэн 2026 оны орлогын санал		Сангийн Яам хянасан		Суурь орлогын зөрүү	Нийт орлогын зөрүү	Хувь /нийт орлого/	2026 оны төсвийн санал /Аймгийн ИТХ/
		Суурь орлого	Нийт орлого	Суурь орлого	Нийт орлого				
1	АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БҮГД	25,678.8	26,360.7	27,333.4	28,020.2	1,654.6	1,659.5	106.3	28,038.3
1.1.	ТАТВАРЫН ОРЛОГО	24,011.9	24,693.8	25,256.9	25,943.7	1,245.0	1,249.9	105.1	25,953.8
1.1.1	Цалин,хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон түүнтэй адилтгах орлогын албан татвар	16,897.7	16,897.7	18,600.0	18,600.0	1,702.3	1,702.3	110.1	18,600.0
1.1.2	Үйл ажиллагааны орлого	588.5	588.5	659.2	659.2	70.7	70.7	112.0	659.2
1.1.3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	3,720.0	3,720.0	2,600.0	2,600.0	(1,120.0)	(1,120.0)	69.9	2,600.0
1.1.4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	319.8	319.8	600.0	600.0	280.3	280.3	187.6	600.0
1.1.5	Шууд бус орлого	15.8	15.8	20.0	20.0	4.2	4.2	126.7	20.0
1.1.6	ХХОАТ буцаалт	(1,630.0)	(1,630.0)	(1,630.0)	(1,630.0)	-	-	100.0	(1,630.0)
1.1.7	Бичил худалдаа, үйлчилгээ эрхэлсний орлого	9.2	12.0	-	-	(9.2)	(12.0)	-	-
1.1.8	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1,800.0	1,800.0	1,800.0	1,800.0	-	-	100.0	1,800.0
1.1.9	Үл хөдлөх хөрөнгийн татвар	408.7	595.7	410.0	605.0	1.3	9.3	101.6	605.0
1.1.10	Бууны албан татвар	78.7	78.7	80.0	80.0	1.3	1.3	101.7	80.0
1.1.11	Авто тээвэр өөр явагч хэрэгслийн албан татвар	425.5	547.8	714.7	837.0	289.2	289.2	152.8	837.0
1.1.12	Улсын тэмдэгтийн хураамж	252.2	271.7	252.2	271.7	-	-	100.0	271.7
1.1.13	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	20.0	20.0	20.0	20.0	-	-	100.0	20.0
1.1.14	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	490.1	490.1	515.0	515.0	24.9	24.9	105.1	515.0
1.1.15	Газрын төлбөр	225.0	534.1	225.0	534.1	-	-	100.0	534.1



1.1.16	Газрын дуудлага худалдааны орлого	10.0	10.0	10.0	10.0	-	-	100.0	10.0
1.1.17	Ойн нөөц ашигласны төлбөр	226.0	226.0	226.0	226.0	-	-	100.0	226.0
1.1.18	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	92.3	92.3	92.3	92.3	-	-	100.0	92.3
1.1.19	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	48.8	89.8	48.8	89.8	-	-	100.0	99.9
1.1.20	Байгалийн ургамал ашигласны төлбөр	13.7	13.7	13.7	13.7	-	-	100.0	13.7
1.2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,666.9	1,666.9	2,076.5	2,076.5	409.6	409.6	124.6	2,084.5
1.2.1	Хүүгийн орлого	-	-	367.6	367.6	367.6	367.6	-	367.6
1.2.2	Торгуулийн орлого	1,258.0	1,258.0	1,300.0	1,300.0	42.0	42.0	103.3	1,300.0
1.2.3	Түрээсийн орлого	27.6	27.6	27.6	27.6	-	-	100.0	27.6
1.2.4	Нэр заагдаагүй бусад орлого	358.0	358.0	358.0	358.0	-	-	100.0	358.0
1.2.5	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20.3	20.3	20.3	20.3	-	-	100.0	20.3
1.2.6	Төсөвт газрын өөрийн орлого	3.0	3.0	3.0	3.0	-	-	100.0	11.0

Сангийн яамнаас татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс суурь орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан нийт дүнгээр **6.3** хувь буюу **1,659.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан. Нэмэгдүүлсэн зарим орлогыг авч үзвэл:

- ❖ Цалин хөлсний орлогын албан татварыг 2026 онд багш, эмч, эмнэлгийн ажилтнууд буюу төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 10 хувь буюу 1,702.3 сая төгрөг,
- ❖ Үйл ажиллагааны орлогын албан татварыг 12.0 хувь буюу 70.7 сая төгрөг,
- ❖ Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг 87.6 хувь буюу 280.3 сая төгрөгөөр,
- ❖ Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 52.8 хувь буюу 289.2 сая төгрөг,
- ❖ Торгуулийн орлогыг 3.3 хувиар буюу 42.0 сая төгрөгөөр,
- ❖ Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх гэрээний эргэн төлөлттэй холбоотой хүүгийн орлогыг 367.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

Монгол Улсын Сангийн сайдаас 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/10180 дугаар албан бичгээр аймгийн 2026 оны төсвийг хүргүүлж, орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулж батлахад баримтлах чиглэл ирүүлсэн байна. Тус чиглэлд орон нутгийн төсвийн орлогыг Сангийн яамны хянасан түвшинд батлах, төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэх, үндэслэлгүйгээр орлого нэмэгдүүлэхгүй байхыг тусгажээ. Үүний хүрээнд Аймгийн 2026 оны орон нутгийн төсвийн орлогод Сангийн Яамнаас хянасан суурь орлого 27,333.4 сая төгрөг дээр суурь болон нийт орлогын зөрүү 686.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, аймгийн ЗДТГ-ын өөрийн орлогыг 8.0 сая төгрөг, усны төлбөрийн 10.1 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн аймгийн төсвийн орлогыг нийт **28,038.3** сая төгрөгөөр батлуулахаар төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн орлогод дүн шинжилгээ хийж орон нутгийн 2026 оны төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс дараах 5 нэр төрлийн орлогыг **486.8** сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг гаргаж байна. Үүнд:

Хүснэгт №6 Татварын болон татварын бус орлого

/сая төгрөг/

№	Орлогын нэр	Сангийн яамны хянасан дүн	Аудитын боломжит санал	Нэмэгдүүлэх хэмжээ
1	Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох татварын орлого	2,600.0	2,900.0	300.0



2	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлого	47.9	62.4	14.5
3	Нэр заагдаагүй бусад орлого	358.0	429.8	71.6
4	Торгуулийн орлого	1300.0	1400.0	100.0
5	Ногдол ашгийн орлого	0	0.7	0.7
Нийт дүн				486.8

Орлогын нэр төрлөөр дэлгэрэнгүй тооцооллын хамт танилцуулбал:

1. ХАДГАЛАМЖИЙН ХҮҮГИЙН ОРЛОГООС ТООЦОХ ТАТВАРЫН ОРЛОГЫГ 300.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ

Хадгаламжийн хүүгийн орлогын тухайд Монгол банкны Архангай салбарын мэдээллээс үзэхэд 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аймгийн арилжааны банкин дахь хадгаламжийн үлдэгдэл **223,101.4** сая төгрөг, 2025 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар хадгаламж **235,641.5** сая төгрөг болж өмнөх оноос 5.6 хувиар өсжээ.

Хүснэгт № 7 Арилжааны банкин дахь хадгаламжийн үлдэгдэл

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Арилжааны банкин дахь хадгаламжийн үлдэгдэл /2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	Арилжааны банкин дахь хадгаламжийн үлдэгдэл /2025 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар/	Зөрүү	Хувь
Хадгаламжийн хүү	223,101.4	235,641.5	12,540.1	5.6

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох татварын орлогыг **3,720.0** сая төгрөгөөр төсөвлөн санал хүргүүлснийг Сангийн Яамнаас **2,600.0** сая төгрөгөөр хянажээ. 2024 онд тус орлогыг 1500.0 сая төгрөг, 2025 онд 3,425.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 123-134.3% -аар давж биелсэн байна.

Хүснэгт №, Сангийн яамнаас хянасан дүн, 2024-2025 оны төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

2026 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн	Сангийн Яамнаас хянасан дүн	2024 он			2025 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Төлөвлөгөө / 10 сараар /	Гүйцэтгэл /10 сараар/	Хувь
3,720.0	2,600.0	1,500.0	1,845.4	123.0	3,425.0	2,399.9	3,423.7	134.3

Аймгийн хэмжээний хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийн үлдэгдэл, жигнэсэн дундаж хүүгийн судалгаанд үндэслэн орлогын тооцооллыг хийхэд хадгаламжийн хүүгийн орлогын албан татвараас 2,089.6 сая төгрөг, Татварын хэлтсийн орлогын саналд тусгагдсан Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашгийн татвараас 834.3 сая төгрөг / 2025 оны гүйцэтгэлийн зөвхөн 50 хувиар тооцсон/ нийт 2,923.9 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжтой байна.

Хүснэгт №9 Хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох ХХОАТ-ын тооцоолол

/сая төгрөг/

Хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ		Нийт хадгаламжийн дүн	Хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хувь хэмжээ		Хадгаламжийн хүүгийн жигнэсэн дундаж хувь хэмжээгээр тооцсон дүн		Нийт хадгаламжийн орлогын дүн / жигнэсэн	Хадгаламжийн хүүгийн ХХОА	Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашгийн татвар / 2025 оны	Нийт төлөвлөж болох орлогын хэмжээ
Хугацаатай хадгаламж	Хугацаагүй хадгаламж		Хугацаатай хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Хугацаатай хадгаламж	Хугацаагүй хадгаламж				



							дунджаар тооцсон /	Т /10 хувь/	гүйцэтгэлийн 50 хувиар тооцсон/	
194,417.5	41,224.0	235,641.5	9.906%	3.973%	19,258.2	1,637.9	20,896.1	2,089.6	834.3	2,923.9

(2025 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар ирүүлсэн Монгол банкны Архангай салбарын мэдээгээр 19 сумын хэмжээнд хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү-9.906%, хугацаагүй хадгаламж - 3.973% байгааг үндэслэн тооцов)

Иймд аудитаас дээрх тооцоо судалгаа, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, өмнөх оны хадгаламжийн өсөлт, Татварын хэлтсийн тооцоо судалгаа зэргийг харгалзан хадгаламжийн хүүгийн орлогоос тооцох татварын орлогыг **300.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэн **2,900.0** сая төгрөгөөр төлөвлөх саналыг гаргаж байна.

2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭЛТЭЙ ХӨРӨНГӨ БОРЛУУЛСНЫ ОРЛОГО БОЛОН ТҮРЭЭСИЙН ОРЛОГЫГ 14.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлогын гүйцэтгэлийг сүүлийн 3 жил, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар авч үзэхэд 2022-2024 онуудад 220-260.5 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт № 10 Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2022 он		2023 он		2024 он		2025 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө /эхний 10 сар/	Гүйцэтгэл /эхний 10 сар/	
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого болон түрээсийн орлого	65.0	143.0	50.0	116.4	62.2	162.1	42.6	36.0	51.6

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тус орлогыг Сангийн Яамнаас 47.9 сая төгрөг хянасан бөгөөд Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн санал, тооцоо судалгаанд үндэслэн тооцоход орлого нийт 62.4 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Үүнд:

- 2026 онд орон нутгийн өмчид бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө буюу ашиглалтгүй байгаа 8 барилгыг хувьчилж хөрөнгө борлуулсны орлогыг 17.0 сая төгрөг
- Булган хангай хорооллын дулааны шугам сүлжээний түрээсийн гэрээгээр эзэмшүүлж, гэрээний төлбөрийг (2024,2025 он) 32.8 сая төгрөг
- Тариат сумын төвийн шинэчлэлийн шугам сүлжээний түрээсийн орлогыг 12.0 сая төгрөг
- Орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууц түрээсийн орлогыг 0.6 сая төгрөг

Хүснэгт №11 Орлогын санал, аудитын санал

/сая төгрөг/

2024 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн	Сангийн Яамнаас хянасан дүн	Орон нутгийн өмчийн газрын санал	Аудитаар төвлөрөх боломжтой дүн	Нэмэгдүүлэх санал
47.9	47.9	62.4	62.4	14.5

Иймд түрээсийн орлогыг Сангийн Яамны хянасан дүнгээс **14.5** сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг гаргаж байна. /эх сурвалж: ОНӨГ-ын 2025 оны 11 дүгээр сарын -ны 454 тоот албан бичиг/



3. НЭР ЗААГДААГҮЙ БУСАД ОРЛОГЫГ 71.6 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ

Нэр заагдаагүй бусад орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл сүүлийн 3 жил 109.4-354.2 хувиар буюу дунджаар 239.4 хувиар давж биелсэн бөгөөд 2025 онд 352.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,203.8 сая төгрөг төвлөрч жилийн төлөвлөгөөг 341.9 хувиар давж биелсэн дүнтэй байна.

Хүснэгт №12. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2022 он		2023 он		2024 он		2025 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө / эхний 10 сар/	Гүйцэтгэл / эхний 10 сар/	
Нэр заагдаагүй бусад орлого	357.5	391.1	360.0	916.9	525.5	1,861.3	352.0	292.7	1,203.8

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын саналд нэр заагдаагүй бусад орлогыг 358.0 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн Яамнаас нэмэгдүүлээгүй хэвээр урьдчилж хянасан.

Хүснэгт №13. Аудитаар орлого нэмэгдүүлэх санал

2026 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн	Сангийн Яамнаас хянасан дүн	Аудитаар төвлөрөх боломжтой дүн	Нэмэгдүүлэх санал
358.0	358.0	429.6	71.6

Иймд нэр заагдаагүй бусад орлогыг өмнөх жилүүдийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн дундаж түвшинд суурилан **71.6** сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналыг гаргаж байна.

4. ТОРГУУЛИЙН ОРЛОГЫГ 100.0 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ

Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр сүүлийн 3 жил 133.1-153.9 хувиар буюу дунджаар 43.0 хувиар давж биелсэн байна. Торгуулийн орлогыг 2025 онд 1,200.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс эхний 10 сарын гүйцэтгэлээр 1,830.2 сая төгрөг төвлөрч жилийн төлөвлөгөөг 152.5 хувиар давж биелсэн.

Хүснэгт №14. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөг/

Орлогын нэр төрөл	2022 он		2023 он		2024 он		2025 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө / жилийн /	Төлөвлөгөө /эхний 10 сар /	Гүйцэтгэл /эхний 10 сар/
Торгуулийн орлого	900.0	1,198.4	1,005.0	1,546.2	1,181.4	1,712.3	1,200.0	993.2	1,830.2

Орон нутгийн 2026 оны төсвийн орлогын саналд торгуулийн орлогыг 1,258.0 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн Яамнаас 3.2 хувиар нэмэгдүүлэн 1,300.0 сая төгрөгөөр хянасан байна.

Иймд торгуулийн орлогыг өмнөх жилүүдийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн



дундаж түвшний хэмжээнд буюу хянасан дүнг **100.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ.

Хүснэгт №15. Аудитаар орлого нэмэгдүүлэх санал

/сая төгрөг/

2026 оны орон нутгийн орлогын төсвийн төсөлд тусгасан дүн	Сангийн Яамнаас хянасан дүн	Аудитаар төвлөрөх боломжтой дүн	Нэмэгдүүлэх санал
1,258.0	1,300.0	1,400.0	100.0

5. НОГДОЛ АШГИЙН ОРЛОГЫГ 0.7 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ

“Архангайд үйлдвэрлэв” ОНӨААҮГ-ын 2025 оны 3 улирлын гүйцэтгэлээр 266.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 247.6 сая төгрөгийн гүйцэтгэлээр зарцуулж зөрүү 18.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын тулгалтаар тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 45.0 сая төгрөгийн ашигтай ажиллах боломжтой байна. Тайлант оны цэвэр ашгийн дүнгийн 1 хувь буюу 0.4 сая төгрөгөөр ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүснэгт №16 Архангай үйлдвэрлэв ОНӨААТҮГ-ын ашгийн тооцоолол

/сая.төгрөг/

2025 оны төлөвлөгөө /нийт ашиг/	2025 оны 10 сарын 31-ны байдлаар Нийт орлого	2025 оны 10 сарын 31-ны байдлаар нийт зардал	11,12 сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр ашгийн дүн	Нийт ашиг	ОАТ/10%/	Цэвэр ашиг	Ногдол ашиг/1%/
12.8	266.0	247.6	26.6	45.0	4.5	40.5	0.405

“Тунгалаг тамир цогцолбор” ОНӨААҮГ-ын 3 улирлын гүйцэтгэлээр 293.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, хүлээгдэж буй гүйцэтгэлээр 259.7 сая төгрөгийн гүйцэтгэлээр зарцуулж зөрүү 33.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын тулгалтаар тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 33.4 сая төгрөгийн ашигтай ажиллах боломжтой байна. Тайлант оны цэвэр ашгийн дүнгийн 1 хувь буюу 0.3 сая төгрөгөөр ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Хүснэгт №17 Тунгалаг тамир цогцолбор ОНӨААТҮГ-ын ашгийн тооцоолол

/сая төгрөг/

2025 оны төлөвлөгөө /нийт ашиг/	2025 оны 10 сарын 31-ны байдлаар Нийт орлого	2025 оны 10 сарын 31-ны байдлаар нийт зардал	11,12 сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр ашгийн дүн	Нийт ашиг	ОАТ/10%/	Цэвэр ашиг	Ногдол ашиг/1%/
26.9	293.1	233.6	22.3	37.1	3.7	33.4	0.334



ГУРАВДУГААР БҮЛЭГ: ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН ТҮВШИНД ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫГ 423.4 САЯ ТӨГРӨГӨӨР ХЭМНЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА

3.1. Төсвийн төслийн саналыг тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөсөн байна

Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсөл боловсруулах журам”-ын дагуу орон нутгийн төсөвт байгууллагуудын 2026 оны төсвийн төслийг холбогдох маягтын дагуу хүлээн авч хянан Сангийн Яамнаас ирүүлсэн ТЭЗ нарын 2026 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж чиглэлийн дагуу нэмэлт тооцооллуудыг хийж, төсвийн урсгал зардлыг төлөвлөжээ.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2025 оны тодотгон баталсан нийт зардлаас 24,655.2 сая төгрөгөөр буюу 39.2 хувь, 2026 оны төсвийн хязгаар¹-аас 28,281.0 сая буюу 47.7 хувиар нэмэгдүүлэн 87,585.6 сая төгрөг байхаар тооцож төсвийн саналыг хүргүүлсэн байна.

Төсвийн хязгаараас хэтрүүлж төлөвлөсөн зардлын тухайд:

- ✓ Аймаг, сумдын ИТХ-ын зардлыг 2,824.2 сая төгрөг буюу 63.3 хувь,
- ✓ Аймгийн засаг даргын харьяа байгууллагуудын зардлыг 9,252.2 сая төгрөг буюу 30.6 хувь,
- ✓ Засаг даргын ерөнхий дансыг 6,804.3 сая төгрөг буюу 235.4 хувь,
- ✓ Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардлыг 7,636.5 сая төгрөг буюу 45.1 хувиар,
- ✓ Хөрөнгийн зардлыг 1,763.8 сая төгрөг буюу 37.2 хувиар өсгөн төлөвлөжээ.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн төслийн саналыг Сангийн яам 30,867.8 сая төгрөгөөр бууруулж 56,717.8 сая төгрөгөөр хянасан байна.

Хүснэгт №18. Төсвийн төслийн харьцуулалтын судалгаа

/сая.төгрөг/

№	Зардлын ангилал	2025 оны тодотголын дүн	2026 оны төсвийн хязгаар	2026 оны төсвийн санал	СЯ-ны хянасан дүн
1	ИТХ-ын дарга	5,273.8	4,463.1	7,287.3	4,910.8
2	Засаг дарга	30,272.9	30,264.1	39,516.3	27,677.7
3	Засаг даргын ерөнхий данс	9,032.0	2,890.1	9,694.4	7,290.2
4	ТБОНӨ-ийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардал:	15,031.4	16,946.1	24,582.6	14,429.1
5	Хөрөнгийн зардал	3,315.3	4,736.2	6,500.0	2,410.0
ДҮН		62,925.4	59,299.6	87,580.6	56,717.8

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийг жил бүр Засгийн газрын тогтоосон төсвийн хязгаараас хэтрүүлэн төлөвлөж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 27 дугаар зүйлийн 27.1.4, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалттай тус тус нийцэхгүй байна. /УАГ-аас Монгол улсын 2026 оны төсвийн төсөлд хийсэн аудитаар Сангийн сайдад зөвлөмж хүргүүлсэн байх тул аудитаас шийдвэр хүргүүлээгүй/

¹ Засгийн газрын 2025 оны 01 дүгээр тогтоол



3.2 Төрийн өмчийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардлыг 453.2 сая төгрөгөөр хэмнэх боломжтой байна

Аймгийн ТЕЗ-аас 2026 онд орон нутгийн төсвөөр 19 хөтөлбөрийг нийт 67,017.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан. Үүнд: аймаг, сумын ИТХ-ын үйл ажиллагааны зардлыг 4,910.8 сая төгрөг, аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг 27,795.8 сая төгрөг, Засаг даргын ерөнхий дансанд 6,870.2 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардалд 14,429.1 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сан 10,101.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 2,910.0 сая төгрөгийг зарцуулахаар байна.

Сангийн Яамнаас хянасан 2026 оны төсөвт дараах өөрчлөлтүүдийг хийж аймгийн ИТХ-аар батлуулах төсвийн төслийг боловсруулсан байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №19. Төсвийн төслийн зохицуулалтын судалгаа

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Сангийн Яам хянасан дүн	Аймгийн ИТХ-аар батлуулах	Зөрүү	Үүнээс:					
					ЗДНХ	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	Усны орлого	Төсөвт байгууллагын	Хөрөнгө оруулалтын зардал
1	Засаг дарга	26,046.6	26,164.7	118.1	-	-	100.0	10.1	8.0	-
1.1	Аймгийн ЗДТГ	3,548.9	3,663.5	114.6	-	-	100.0	6.6	8.0	-
1.2	ЗДНХ	829.6	639.6	(190.0)	(190.0)	-	-	-	-	-
1.3	Сумдын ЗДТГ	20,005.6	20,512.6	507.0	190.0	317.0	-	-	-	-
1.4	Байгаль орчны газар	1,662.5	1,349.1	(313.5)	-	(317.0)	-	3.5	-	-
2	Засаг даргын ерөнхий данс	800.3	380.3	(420.0)	-	-	80.0	-	-	(500.0)
2.1	Мал хамгаалах сан	-	80.0	80.0	-	-	80.0	-	-	-
2.2	Усан хангамжийн татаас	800.3	300.3	(500.0)	-	-	-	-	-	(500.0)
3	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	2,409.9	2,909.9	500.0	-	-	-	-	-	500.0
3.1	Их засвар	2,409.9	2,909.9	500.0	-	-	-	-	-	500.0

Хүснэгтээс харахад урьд оны үлдэгдлээс 180.0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын болон мал хамгаалах санд, байгаль орчны газрын төсвөөс сумдын тамгын газарт 317.0 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардалд, усан хангамжийн татаасын зардлаас хөрөнгө оруулалтын зардалд 500.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.



Аймгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн сайдаас өгсөн чиглэл, удирдамжийн дагуу төрийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэх, төрийн албан хаагчдын орон тоог бууруулж, орон тооны тэлэлтийг хязгаарлах бодлогын хүрээнд цалингийн зардлын өсөлтийг хязгаарлах, төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын 50.0 хувийг 2027 оны төсөвт шилжүүлэх зэрэг улсын хэмжээний нэгдсэн бодлогыг баримтлан өмнөх оны тодотгосон төсвөөс 9.4 хувиар буюу 6,921.9 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

Хүснэгт №20. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зарлагын судалгаа

/сая.төгрөг/

№	Байгууллагын нэр	2025 оны төсвийн тодотгол	Сангийн яамны хянасан дүн	2026 оны Аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх дүн	Өөрчлөлт дүн	Өөрчлөлт хувь
1	2	3	4	5	6=5-3	7
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	5,273.8	4,910.8	4,910.8	(362.9)	(6.9)
1.1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1,287.1	672.4	672.4	(614.7)	(47.8)
1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	216.0	479.3	479.3	263.3	121.9
1.3	Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	3,770.7	3,759.1	3,759.1	(11.5)	(0.3)
2	Засаг дарга	30,272.9	27,677.7	27,795.8	(2,477.0)	(8.2)
2.1	Аймгийн Засаг даргын тамгын газар	5,357.6	3,548.9	3,663.4	(1,694.2)	(31.6)
2.2	Засаг даргын нөөц хөрөнгө	1,322.5	829.6	639.6	(682.9)	(51.6)
2.3	Сумдын Засаг даргын тамгын газар	19,868.3	20,005.6	20,512.6	644.3	3.2
2.4	Орон нутгийн өмчийн газар	458.3	383.7	383.7	(74.6)	(16.3)
2.5	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	536.3	407.1	407.1	(129.2)	(24.1)
2.6	Байгаль орчны газар	1,678.7	1,662.5	1,349.1	(329.6)	(19.6)
2.7	Сумдын ойн анги	617.2	575.8	575.8	(41.4)	(6.7)
2.8	Худалдан авах ажиллагааны газар	347.4	264.6	264.6	(82.8)	(23.8)
	Архивын хэлтэс	86.6	-	-	(86.6)	(100.0)
3.	Засаг даргын ерөнхий данс	9,032.0	7,290.2	6,870.2	(2,161.8)	(23.9)
3.1	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	592.6	546.2	546.2	(46.4)	(7.8)
3.2	Мал эмнэлгийн үйлчилгээний хөлс	574.0	529.1	529.1	(44.9)	(7.8)
3.3	Цэцэрлэг хотын хот тохижилтын газар /ОНӨААТҮГ/ олгох татаас	1,575.9	1,702.2	1,702.2	126.3	8.0
3.4	Орон нутгийн авто замын сан	1,152.1	1,427.0	1,427.0	274.9	23.9
3.5	Хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээ	273.4	252.0	252.0	(21.4)	(7.8)
3.6	Ахмадын байгууллага	82.9	94.9	94.9	11.9	14.4
3.7	Дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн төлбөр	444.8	367.6	367.6	(77.2)	(17.4)
3.8	Гамшгийн зардал	300.0	-	-	(300.0)	(100.0)
3.9	Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	1,575.0	1,451.8	1,451.8	(123.2)	(7.8)
3.10	Халамжийн сан	136.1	119.3	119.3	(16.8)	(12.4)
3.11	Мал хамгаалах сан	80.0	-	80.0	-	-



3.12	УТ байгууллагын ТЗ-ны албан хаагчдын ОН-ын нэмэгдэл	2,245.3	-	-	(2,245.3)	(100.0)
3.13	Усан хангамжийн татаас (Архангай ус суваг ОНӨААТҮГ)	0.0	800.3	300.3	300.3	-
4	Төрийн болон орон нутгийн өмчийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардал:	15,031.4	14,429.1	14,429.1	(602.3)	(4.0)
4.1	Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал	15,031.4	14,429.1	14,429.1	(602.3)	(4.0)
5	Орон нутгийн хөгжлийн сан	11,013.5	-	10,101.1	(912.4)	(8.3)
5.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	4,929.7	-	4,208.7	(720.9)	(14.6)
5.2	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	6,083.8	-	5,892.4	(191.5)	(3.1)
6	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	3,315.3	2,410.0	2,910.0	(405.4)	(12.2)
6.1	Их засвар	3,315.3	2,410.0	2,910.0	(405.4)	(12.2)
Нийт дүн		73,938.9	56,717.8	67,017.0	(6,921.9)	(9.4)

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөв:

- ✓ Аймгийн ИТХ-ын 2026 оны үйл ажиллагааны зардлыг өмнөх оны төсвөөс 614.7 сая төгрөгөөр бууруулан батлуулахаар төлөвлөсөн нь 2025 оны төсвийн тодотголын дүнтэй харьцуулахад үндсэн үйл ажиллагааны зардлыг 108.5 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэгийн зардлыг 64.2 сая төгрөгөөр бууруулж, сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж 19.5 сая төгрөгөөр нэмж батлагдсан. Мэдээлэл сурталчилгааны зардал, зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс, ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал Сангийн яамнаас хянагдаагүй байна.
- ✓ Харин хүү торгуулийн орлогын 2025 оны гүйцэтгэлийн дүнтэй холбоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын дүнг өмнөх оноос 263.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж хянасан байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас хийж байгаа завсарын аудитаар аймгийн ИТХ-ын зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс, ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын холбогдох заалтуудтай уялдахгүй зарцуулагдсан байна. Иймд орон нутгийн орлогын өсөлттэй холбоотой дээрх зардлуудад өөрчлөлт оруулах тохиолдолд холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Сүүлийн жилүүдэд торгуулийн орлогын төвлөрүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал орон нутгаас төлөвлөсөн хэмжээнээс өндөр дүнгээр хянагдаж байна. Үүнтэй холбоотой хууль, хүчний байгууллагуудад дээрх зардлыг хэт жижиглэн хуваарилж байгаагаас гэмт хэрэг, зөрчлийн тоо төдийлөн буурахгүй, гэр бүлийн хүчирхийлэл, хүрээлэн буй орчин, цахим гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгийг үр дүнтэй зарцуулах нэгдсэн бодлого шаардлагатай байгаа нь ажиглагдсан.

Засаг даргын харьяа байгууллагуудын төсвийн талаар:

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг 2025 оны төсвийн тодотголоос 2,477.0 сая төгрөгөөр бууруулан аймгийн ИТХ-аар батлуулахаар төлөвлөсөн байна. Үүнд:



- ✓ Аймгийн ЗДТГ-ын тухайд 1,694.2 сая төгрөгөөр бууруулан батлуулахаар төлөвлөсөн нь цалингийн зардлыг 648.6 сая төгрөгөөр, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой албан томилолтын зардлыг 113.8 сая төгрөгөөр бууруулсан.
- ✓ Сумдын ЗДТГ ын тухайд 644.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговортой холбоотой байна.
- ✓ Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг Сангийн Яамны хянасан түвшинд төлөвлөж, өмнөх оноос 682.9 сая төгрөгөөр бууруулсан байна.
- ✓ Байгаль орчны газрын зардлыг 329.6 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эд хогшил, урсгал засварын зардал буурсантай холбоотой байна.

Засаг даргын ерөнхий дансны төлөвлөлтийн талаар:

Засаг даргын ерөнхий дансыг 2025 оны төсвийн тодотголоос 2,161.8 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна. Үүнд:

- ✓ Улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийн 2,245.3 сая төгрөгийг Сангийн яамнаас хянаагүй байна.
- ✓ Гамшгаас хамгаалах зардлыг 2026 онд төлөвлөөгүй байна.
- ✓ Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг 123.2 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.
- ✓ Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг 91.3 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн. Мал эмнэлгийн үйлчилгээний зардлыг 2025 онд төсвийн тодотгол хийж бууруулсантай холбоотой 48 байгууллагад 575.3 сая төгрөгийн өр төлбөр үүсэх эрсдэл бий болсон байна. 2026 онд Сангийн яам төсвийг бууруулан хянасан нь дээрх өр төлбөрийг бүрэн барагдуулсаны дараа мал эмнэлгийн үйлчилгээг хэвийн хэмжээнд үзүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.
- ✓ Усан хангамжийн татаас (Архангай ус суваг ОНӨААТҮГ)-ын зардлыг 2026 онд нэмж төлөвлөсөн байна. /Төсвийн төслийн төлөвлөгөөнөөс Сангийн яам 7.8 хувиар бууруулан 800.3 сая төгрөгөөр хянасныг аймгийн ИТХ-д усан хангамжийн татаас 300.2 сая төгрөгөөр, их засварын зардалд 500.0 сая төгрөгийг батлуулахаар төлөвлөжээ
- ✓ Цэцэрлэг хотын хот тохижилтын газар /ОНӨААТҮГ/ олгох татаасыг 126.3 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.
- ✓ Орон нутгийн авто замын сангийн тухайд өмнөх онуудын хүү торгуулийн орлогын төвлөрүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой 274.9 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардлын тухайд:

Орон нутгийн төсвөөс улсын төсвийн эрүүл мэнд, мэргэжлийн боловсрол, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёл спортын салбарын нийт 110 байгууллагын тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардлыг олгож байна.

Тайлант онд түлш халаалтын зардалтай холбоотой дараах шийдвэрүүд гарч үнэ тариф нэмэгдэхээр төсвийн төсөлд тусгажээ. Үүнд:

Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 164 дүгээр тогтоолоор "Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийг шинэчлэн баталсан байна. Ингэснээр талбайн хэмжээгээр тооцогддог дотуур байртай аймаг, сумын нийт 9 сургуулиудын тухайд дулааны төлбөр нь эзэлхүүний хэмжээгээр тооцогдох болсноор түлш халаалтын зардал нь нэмэгдэж болзошгүй байна. Гэвч Сангийн яамнаас хуучин тарифаар хянасан байна.



Засгийн газрын 2025 оны 132 дугаар “Олон улсын худалдааны тарифын нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор бүх төрлийн үйлчилгээний төлбөр, хураамжийг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлэхгүй байх шийдвэр гарсны улмаас 2025 оны тухайд үнийн өөрчлөлт гараагүй боловч 2026 онд дээрх шийдвэрүүд хэрэгжиж эхлэхээр байна.

Эрчим хүчний зохицуулах хороо “Эх голомтын илч” ХХК-ын дулааны НӨАТ тооцогдсон тарифыг 1 м.куб нь 36.5 хувиар буюу 3069 төгрөг болж нэмэгдүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой аймгийн төвийн байгууллагууд түлш халаалтын зардлын дүнг нэмэгдүүлэн төлөвлөж, Сангийн ямаар хянуулсан байна.

Хүснэгт №21. Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад олгох тогтмол зардлын судалгаа

№	Салбар	Байгууллагын Тоо	2025 оны тодотголын дүн	2026 оны санал	СЯ-аас хянагдсан дүн	ИТХ-аар батлуулах
1	Эрүүл мэнд	20	2,874.3	3,438.1	2,885.5	2,885.5
2	Ерөнхий боловсролын сургууль	32	6,479.9	9,548.8	5,804.0	5,804.0
3	Сургуулийн өмнөх боловсрол	35	2537.4	3,991.5	2,347.0	2,347.0
4	Соёл	22	1,770.9	2,947.0	2,049.1	2,049.1
5	Спорт	1	1,368.9	1,764.5	1,343.4	1,343.4
Дүн		110	15,031.4	21,689.9	14,429.0	14,429.0

Аймгийн төвийн байгууллагуудын дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж төлөвлөсөн боловч 2025 оны тодотгосон төсвөөс буурсан нь өмнөх онуудад төсвийн төслийг боловсруулахдаа бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэж төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Аймгийн Хөгжимт драмын театрын шинээр ашиглалтанд орох барилга, нэгдсэн халаалтанд шинээр холбогдох Цэнхэр сумын Соёлын төвийн барилгын зардлыг нэмж төлөвлөсөнтэй холбоотой соёлын салбарт 278.3 сая, тогтмол зардлын тооцоо судалгаа дутуу хийгдснээс аймгийн Биеийн тамир спортын газарт 134.5 сая, эрүүл мэндийн салбарт 40.4 сая, нийт 453.2 сая төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой байх тул зардлыг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулахад анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Орон нутгийн төсвийн байгууллагын орон тооны тухайд:

Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд баримталсан бодлого, Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлогын хүрээнд Сангийн яамнаас нийт төрийн албан хаагчдыг 22 хувь буюу 165-аар бууруулан 582 орон тоогоор хянасан байна.



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 32 ХУВЬ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА

4.1. Орон нутгийн төсвөөр 2026 онд шинээр хэрэгжүүлэх 20 төсөл, арга хэмжээний 50 хувь нь аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.

Төсвийн төсөлд аймгийн ОНХС, авто замын сан, ОНТХО-ын эх үүсвэрээр 2026 онд шинээр хэрэгжүүлэх 8,972.1 сая төгрөгийн 20, өмнөх оноос үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 3,297.9 сая төгрөгийн 5, нийт 12,270.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээг 8,545.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад 2026 онд 8,545.6 сая төгрөгийн санхүүжилтийн 12.5 хувийг өмнөх оноос шилжих, 87.5 хувийг шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээнд зарцуулахаар тусгасан байна.


Хүснэгт 22. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө /сая төгрөг/

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Шинэ төсөл, арга хэмжээ			Шилжих төсөл, арга хэмжээ			Нийт төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
ОНХС	14	5,708.7	4,208.7				14	5,708.7	4,208.7
ОНТХО	5	2,157.3	2,157.3	4	1,824.9	752.6	9	3,982.2	2,909.9
Авто замын сан	1	1,106.1	1,106.1	1	1,473.0	320.9	2	2,579.1	1,427.0
Нийт	20	8,972.1	7,472.1	5	3,297.9	1,073.5	25	12,270.0	8,545.6

Эх сурвалж: Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2026 оны төсвийн төсөл

Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжих хугацаа 2025 онд дуусаж байгаа ба бөгөөд 2026-2030 онд баримтлах таван жилийн үндсэн чиглэл батлагдаагүй, боловсруулах үе шатанд байгаа тул орон нутгийн 2026 оны төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байна.

Дүрслэл. №2 Орон нутгийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь



Аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан нийт хөрөнгө оруулалтын 56 хувь буюу 14 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн 4,208.7 сая төгрөгөөр, 8 хувь буюу 2 арга хэмжээг авто замын сангийн 1,427.0 сая төгрөгөөр, 36 хувь буюу 9 төсөл, арга хэмжээг аймгийн ОНТХО-ын 2,909.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус тусгажээ.

Орон нутгийн 2026 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20 төсөл, арга хэмжээний 50 хувь буюу 10 төсөл, арга хэмжээг аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ болон хөтөлбөрийн үр дүнтэй уялдуулж төлөвлөөгүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын



тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17², 6.10.4³ дэх заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 23. Хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжүүлэх дүн
1	ОНТХО	Ерөнхий боловсролын сургуулийн 75 ортой дотуур байрын их засвар (Жаргалант сум)	2026-2026	275.6	275.6
2		Ерөнхий боловсролын сургуулийн их засвар (Хайрхан сум)	2026-2026	590.1	590.1
3		Сургуулийн их засвар (Хангай сум)	2026-2026	490.1	490.1
4		1 дүгээр сургуулийн дотуур байрны их засвар (Эрдэнэбулган сум)	2026-2026	649.5	649.5
5		Цэцэрлэгийн гадна цахилгааны ажил (Жаргалант сум)	2026-2026	152.0	152.0
6	ОНХС	Нэгдсэн эмнэлгийн туслах үйлчилгээний цогц барилга (оролцоо)	2026-2026	2,000.0	500.0
7		Тээлийн гүүрний засвар (Батцэнгэл сум)	2026-2026	100.0	100.0
8		Цэвэр, бохирын шугам сүлжээний шинэчлэлийн ажил (Эрдэнэбулган сум)	2026-2026	300.0	300.0
9		Ахмадын амралтын тоног төхөөрөмж	2026-2026	200.0	200.0
10		Нэгдсэн хогийн цэгийг байнгын ажиллагаатай булшлах ажил (Эрдэнэбулган сум)	2026-2026	150.0	150.0
Нийт дүн				4,907.3	3,407.3

Иймд тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд суурилах, хөгжлийн бодлого, төлөвлөлттэй бүрэн уялдуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй орон нутгийн хөгжлийн сангийн 1,450.0 сая төгрөгийн 7, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 490.1 сая төгрөгийн 1, нийт 1,940.1 сая төгрөгийн 8 ТАХ-ийг тусгасан байна.

Хүснэгт №24. Төсөвлөлтийн шаардлага хангасан эсэх мэдээлэл /сая.төгрөг/

Ангилал	Нийт ТАХ			Төсөвлөлтийн шаардлага хангаагүй			ТАХ-ний тоонд харьцуулсан хувь
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүж их дүн	
Аймгийн ОНХСан	14	5,708.70	4,208.70	7	1,450.00	1,450.00	50.0
Авто замын сан	2	2,579.10	1,427.00	-	-	-	
Аймгийн ОНТХО	9	3,982.20	2,909.90	1	490.10	490.10	11.1
Нийт	25	12,270.0	8,545.6	8	1,940.1	1,940.1	32.0

Энэ нь Төсвийн төсөлд тусгасан нийт хөрөнгө оруулалтын дүнгийн 32 хувийг эзэлж

² 5.2.17-д "төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим" гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг"

³ 6.10.4-д "орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх"



байгаа бөгөөд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байх тул зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүллээ.

ОНХС-ийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан байна

Сангийн Сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.1⁴ дэх заалтын хүрээнд аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/476 дугаар захирамжаар аймгийн 2026 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдийн оролцоотой төлөвлөж, жагсаалт боловсруулах ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Энэ ажлын хэсгээс 2026 онд 5,763.5 сая төгрөгийн 27 ТАХ-г хэрэгжүүлэх жагсаалтыг боловсруулж, 5 салбарын чиглэлээр 50 гаруй албан хаагчдын дунд хэлэлцүүлгийг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж ТАХ-г эрэмбэлсэн нь “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.2⁵ дахь заалттай нийцэж байна.

4.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээг арвилан хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөхгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүл 25 төсөл, арга хэмжээний 15.8 хувь нь барилга байгууламж, 41.0 хувь нь их засварын ажил, 12.3 хувь нь тоног төхөөрөмж бэлтгэх, 10 хувь нь ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, 20.2 хувь нь зам, гүүр засварын ажил, 0.6 хувь нь бусад хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Хүснэгт 25. Төсөл, арга хэмжээний ерөнхий мэдээлэл

(сая төгрөг)

Ангилал	ОНХС			ОНТХО			Авто замын сан			Нийт төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүү үжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүү жих дүн
Барилга байгууламж	5	2,850.0	1,350.0							5	2,850.0	1,350.0
Их засвар	1	600.0	600.0	9	3,982.3	2,909.9				10	4,582.3	3,509.9
Тоног төхөөрөмж	4	1,050.0	1,050.0							4	1,050.0	1,050.0
ТЭЗҮ	1	858.7	858.7							1	858.7	858.7
Зам, гүүр засвар	2	300.0	300.0				2	2,579.1	1,427.0	4	2,879.1	1,727.0
бусад	1	50.0	50.0							1	50.0	50.0
Нийт	14	5,708.7	4,208.7	9	3,982.3	2,909.9	2	2,579.1	1,427.0	25	12,270.1	8,545.6

Төсвийн төсөлд тусгагдсан барилга байгууламж, их засварын 15 төсөл, арга хэмжээний 890.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ нь “сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх” гэсэн төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй байгаа бөгөөд Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Засгийн газрын

⁴ 7.1-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна”

⁵ 7.2-т “Аймаг, нийслэл нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсгээр хянаж эрэмбэлүүлнэ”



2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.1, 3.2.2.2, 3.2.3.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Үүнд: Дараах ажлууд хамаарна.

1. Сургуулийн их засвар (Хангай сум) 490.1 сая төгрөг
2. Сумын төвийн тохижилт (Цэцэрлэг сум) 100.0 сая төгрөг

Дүрслэл №3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ /2025, 2026 он/



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний тоо 2026 онд 8 буюу 32 хувь болж өмнөх онтой харьцуулахад 8 буюу 15 нэгж хувиар буурсан байна. Төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг магадлалаар баталгаажсан зураг, төсвийн дүнд үндэслэхгүйгээр төлөвлөж, төсөвт тусгах нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг дагуулж байна.

Аудитаас Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-д заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т хүргүүлээ.

Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг тусгасан байна.

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

Орон нутгийн 2026 оны авто замын сангийн хөрөнгөөр “Цэцэрлэг хотын төв доторх хатуу хучилттай авто зам, засвар арчлалт, тохижилт”-ын ажлыг үргэлжлүүлж хийхээр 1,427.0 сая төгрөгийн төсвийг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4⁶ дэх заалт, МУЗГ-ын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх захирах зарцуулах журам”-ын дагуу төлөвлөсөн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20⁷ дугаар зүйлийн 20.1.18⁸ дах заалтын хүрээнд боловсролын салбарын барилга байгууламжийн их засварт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 2024 онд **66.5 хувь**, 2025 онд **91.1 хувийг** тус тус санхүүжүүлсэн бол 2026 онд **100 хувь** зарцуулахаар төлөвлөсөн байна.

⁶ 24.4. Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжид санхүүжүүлнэ.

⁷ 20 дугаар зүйл “Орон нутгийн чиг үүрэг”

⁸ Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар”



Хүснэгт №26. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт салбараар 3 жилийн байдлаар

/сая төгрөг/

Салбараар	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт						Нийт хөрөнгө оруулалтын эзлэх хувь		
	2024		2025 оны 10.31-ны байдлаарх гүйцэтгэл		2026 оны төсвийн төслөөр		2024	2025	2026
	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн			
Боловсрол	9	2,082.4	8	2,719.7	9	2,909.9	66.5	91.1	100.0
Соёл урлаг	2	515.7	1	154.2			16.5	5.2	
Аймгийн ЗДТГ-ын дээврийн засвар	1	511.1					16.3	-	
ТЭЗҮ, Зураг төсөв	1	24.3					0.8	-	
Эрдэнэмандал сумын ЗДТГ-ын их засвар			1	112.8				3.8	
Нийт дүн	13	3,133.5	10	2,986.7	9	2,909.9	100.0	100.0	100.0

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг бодитой тооцсон эсэхийг үнэлэх боломжгүй байна.

“Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023-2024 онд дамжин хэрэгжсэн 138.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ихтамир сумын арьс шир боловсруулах цэгийн барилга”-ын зарим ажлын гүйцэтгэл дутуу, чанар байдал хангалтгүй, ашиглагч байгууллагын зүгээс зориулалтаар нь ашиглах боломжгүй гэж үзэн бүртгэл тайланд тусгаагүй ба одоогоор Ихтамир сумын ЗДТГ нь агуулахын зориулалтаар ашиглаж байгаа мөн Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн “Мал нядалгааны цэгийн хөргүүрийн барилга” барих 99.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл арга хэрэгжилтийг газар дээр нь очиж шалгахад зарим ажлыг дутуу хийсэн, чанар байдал хангалтгүй, чанар стандартын шаардлага хангаагүй гэх шалтгаанаар ашиглагч байгууллага үндсэн хөрөнгөнд бүртгээгүй ашиглалтгүй буюу үр нөлөөгүй хөрөнгө оруулалт байсан зөрчил илэрч байсан.

Уг аудитаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан нь төсөл, арга хэмжээний үр нөлөөг бодитой тооцоогүй, төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удаашрах эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

Аудитаас төсвийн төсөлд тусгуулахаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал ирүүлэхдээ техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, тоног төхөөрөмж бүрийн нэр, тоо хэмжээ, нэгжийн өртөг, техникийн үзүүлэлт, түүний үндэслэл тооцооллыг нарийвчлан тодорхойлж төлөвлөх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.



БҮЛЭГ 5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТИЙГ САНГИЙН САЙДЫН 2012 ОНЫ 244 ДҮГЭЭР ТУШААЛЫН ДАГУУ БОЛОВСРУУЛСАН БАЙНА

5.1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 19 хөтөлбөрт 67,016.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.5.6-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж, дараах зүйлийг тусгана" гэж заасан байна.

Үүний дагуу 2026 онд орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх ТЕЗ-ийн нийт 19 хөтөлбөрт 67,016.7 сая төгрөгийг зарцуулахаар хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг боловсруулсан байна. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №27. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, зарцуулах төсөв

(сая төгрөг)

№	Хөтөлбөрийн код	Хөтөлбөрийн нэр	2025 оны тодотгон баталсан	2026 оны өргөн мэдүүлсэн
1	70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	5,273.8	5,076.0
2	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	36,019.9	31,439.0
3	70417	Мэргэжлийн хяналт /СХДА/	536.3	407.1
4	70418	Худалдан авах ажиллагаа	347.4	264.5
5	70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	458.3	383.7
6	70501	Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг /ОНХС/	11,013.5	10,101.1
7	70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	1,166.6	1,075.3
8	71403	Ойжуулалт	617.2	575.7
9	71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,678.7	1,349.1
10	71502	Хот байгуулалт, тохижилт	1,575.9	1,702.1
11	71601	Нийгмийн эрүүл мэнд	2,874.3	2,885.5
12	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ		
13	71701	Биеийн тамир спорт	1,368.9	1,343.4
14	71702	Соёл урлаг	1,771.9	2,049.1
15	71801	Сургуулийн өмнөх боловсрол	2,537.4	2,346.9
16	71802	Ерөнхий боловсрол	6,218.1	5,550.0
17	71804	Мэргэжлийн боловсрол	261.7	254.0
18	71902	Нийгмийн халамж	136.1	119.3
19	72208	Ахмад настны хөгжил хамгаалал	82.9	94.9
Нийт төсөв			73,938.9	67,016.7



Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2025 оны тодотгосон төсвөөс 6,922.2 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар бууруулан 67,016.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг Сангийн яамнаас бууруулан хянасан нь дараах бодлого, зарчмыг баримталсантай холбоотой байна. Үүнд:

- ✓ Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд баримталсан бодлого, төрийн албан хаагчдын чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах,
- ✓ Төрийн хэмнэлтийн бодлогыг үргэлжлүүлэх;
- ✓ Төрийн албан хаагчдын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлын 50.0 хувийг 2027 оны төсөвт шилжүүлэх,

5.2. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг иж бүрэн тодорхойлсон байна

Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийг Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн Төсвийн төсөл боловсруулах журам”-ын хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь түвшин, зорилтод түвшин, зарцуулах төсөв гэсэн үзүүлэлтүүдийг тусган бүрэн тодорхойлсон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх зарим арга хэмжээний өмнөх оны зарцуулалтыг авч үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас эмч, багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 2024 онд 352.0 сая төгрөг, 2025 онд 524.2 сая төгрөгийг шагнал, урамшуулалд зарцуулсан байна. Гэтэл 2026 оны төсвийн төсөлд дахин багш, эмч нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангахад нийт 510.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.
- ✓ Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2024 онд 1,695.3 сая төгрөг, 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 988.4 сая төгрөг нийт 2,683.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарцуулалтаас харахад 23.1 хувь буюу 618,635.3 сая төгрөгийг зочид, төлөөлөгчдийн байр, хоол хүнсэнд 11.6 хувь буюу 310.6 сая төгрөгийг хүлээн авалтад, 9.1 хувь буюу 243.5 сая төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд, 11.4 хувь буюу 305.7 сая төгрөгийг шагналд зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл 2024 оны жилийн эцэс, 2025 оны 3 дугаар улирлын байдлаарх нийт зарцуулалтын 55.1 хувь нь шагнал, хоол байр, хүлээн авалт, бэлэг дурсгал зэрэг Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардал арга хэмжээнд зарцуулсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2026 онд дээрх зардлуудыг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, хэмнэлтийн горимыг баримталж, төсвийн сахилга баттай, хариуцлагатай байх зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж үр ашгийг дээшлүүлж ажиллах саналыг хүргүүлж байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 78.6 хувийг хэрэгжүүлсэн байна

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй. Энэ нь өмнөх аудитын үр нөлөөг баталгаажуулж, дараагийн аудитын чанар, үр нөлөөг сайжруулах нөхцөл болох бөгөөд аудитын үнэ цэнийг нэмэгдүүлэх, зорилтот хэрэглэгчийг өмнө хийсэн аудитын тайлан болон



тухайн үеийн нөхцөл байдлыг эргэн санах, дүгнэх боломж олгодог чухал ач холбогдолтой аудитын үе шат юм.

Өмнөх онд аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төслийн аудитаар аймгийн Засаг даргад зөрчлийг арилгах таслан зогсоох дараах **5-н** албан шаардлага хүргүүлснийг ирүүлсэн нотлох баримтаар шинжлэн судалж үзэхэд нийт шийдвэрийн 78.6 хувийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт № 28. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

№	Шийдвэрийн товч утга	Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжилт үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	Аймгийн 2025 оны төсвийн төслийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу иж бүрэн боловсруулж ирүүлээгүй өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид	Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын дагуу боловсруулж, иж бүрдлийг бүрэн хангаж ирүүлсэн.	100
2	Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхойгүй тооцоо судалгаагүйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 480.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, СТСХ-ийн дарга Ж.Мөнхбат	Албан шаардлагын хариуг аймгийн Засаг даргын 2025.09.09-ны өдрийн 02/1250 дугаар албан бичгээр ирүүлсэн бөгөөд аймгийн ИТХ-аас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг ГХУСАЗСЗ-ийн 2024 оны жилийн эцсийн тайлан, 2025 оны хагас жилийн ажлын тайлан, ГХУСАЗСЗ-ийн 2026 оны урьдчилсан төлөвлөгөөг авч 2026 оны төсвийн төсөлд урьдчилсан байдлаар нэгтгэхдээ холбогдох тооцоо саналыг авч Сангийн яаманд хянуулж ажилласан байна.	100
3	Хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээнд 358.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй, гэрээний нөхцөл тодорхойгүй нарийвчилсан журамгүй байна.	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид, СТСХ-ийн дарга Ж.Мөнхбат, ХБТХОХ-ийн бодлого дарга А.Батболд	Албан шаардлагын биелэлтийг аймгийн Засаг даргын 2025.06.10-ны өдрийн 06/836 дугаар албан бичгээр ирүүлсэн. Нийтийн тээврийн үйлчилгээний гэрээний нөхцөлийг шинэчилсэн, Arabus гар утасны аппликейшн (application) ашиглан нийтийн тээврийн цагийн хуваарь урсгалыг хянах боломжтой болсон байна. Аймгийн Засаг даргын 11 сарын 14-ний 01/1544 дугаар албан бичигт 2025 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээний санхүүжилт олгоогүй бөгөөд төсвийн тодотголоор 274.4 сая төгрөг болж буурсантай холбоотой гэрээнд нэмэлт өөрчлөлт орох нөхцөл үүссэн байх тул биелэлтийг 75 хувиар үнэллээ.	75



4	Төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулан батлуулах	Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид	Аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан 8,545.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 25 төсөл, арга хэмжээг төсөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг шалгахад орон нутгийн хөгжлийн сангийн 1,450.0 сая төгрөгийн 7, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 490.1 сая төгрөгийн 1 нийт 1,940.1 сая төгрөгийн 8 ТАХ нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй, хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргаагүй байх тул хэрэгжилтийг 68 хувиар үнэллээ.	68
5	Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаагүй 24 төсөл арга хэмжээг орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн бодлого дарга А.Батболд	Орон нутгийн 2026 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 20 төсөл, арга хэмжээний 50 хувь нь аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэх чиглэл, зорилт, арга хэмжээ болон хөтөлбөрийн үр дүнтэй уялдсан байна. Иймд биелэлтийг 50 хувиар үнэллээ.	50
Шийдвэрийн хэрэгжилтийн хувь дунджаар				78.6



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй бүрэн уялдаагүй байна.
2. Орон нутгийн 2026 оны төсвийн суурь орлогыг 27333.4 сая төгрөг, нийт орлогыг 28038.3 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
3. Орон нутгийн төсвийн орлогыг 486.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
4. Төсвийн төслийн саналыг тогтоосон хязгаараас хэтрүүлэн төлөвлөсөн байна.
5. Төрийн өмчийн барилга үйлчилгээ, ашиглалтын зардлыг 453.2 сая төгрөгөөр хэмнэх боломжтой байна
6. Нийт хөрөнгө оруулалтаар 2026 оноос шинээр хэрэгжүүлэх 20 төсөл, арга хэмжээний 50 хувь нь аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
7. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй 8 төсөл арга хэмжээг 1,940.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна
8. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тодорхойлсон байна.
9. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн 78.6 хувийг хэрэгжүүлсэн байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙГ САНГИЙН ЯАМНЫ ХЯНАСАН ТҮВШИНД БОЛОВСРУУЛСАН БАЙНА.

Аудитаар нийт 1,940.1 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд 2 албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Б.ЦЭРЭННАДМИДАД

1. Тухайн жилийн төсвийн төслийг аймгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулахад анхаарах
2. Аудитаас төсвийн төсөлд тусгуулахаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал ирүүлэхдээ техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, тоног төхөөрөмж бүрийн нэр, тоо хэмжээ, нэгжийн өртөг, техникийн үзүүлэлт, түүний үндэслэл тооцооллыг нарийвчлан тодорхойлж төлөвлөх
3. Төсвийн үр ашгийг дээшлүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн, тэвчиж болох зардлыг төсөвт төлөвлөхгүй байх арга хэмжээ авч, төвлөрүүлэн захирагч нарт чиглэл өгч ажиллах



Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 12 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139
Утас/Факс: (976) 7033 3231,
Цахим шуудан: info@arkhangai.gov.mn,
Цахим хуудас: www.arkhangai.gov.mn

2025.11.25 № 01/1592
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн 2026 оны төсвийн төслийн нийцлийн
аудитын тайлантай танилцлаа. Нэмэлт санал
тайлбар байхгүй болно.



Б.ЦЭРЭННАДМИД

Магварал В. Цог-Арслан
Тангын дарга

952500500601



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 26 өдөр

Дугаар 01/44

Эрдэнэбулган сум

Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх” аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
4. Шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аудитын менежер (Д.Нэргүйбаатар)-т даалгасугай.
5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг архивын нэгж болгож, архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Цог-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг эрх зүйч аудитор (Б.Анхтуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



ТУШААЛЫН ХАВСРАЛТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудиторын 2025 оны 7 дугаар сарын 25-ний өдрийн 524/A0370216 дугаар
тушаалын хавсралт

"Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын бүртгэл

Аудитын нэр: "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх"

Аудитын код: АРА-2025/07/01-ШТА-НА

"Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" нийцлийн аудитаар хүргүүлсэн шийдвэрийн							
Д/д	Алдаа зөрчлийн товч утга	Тоо	Мөнгөн дүн /мян.төг/	Төрөл	Огноо	Дугаар	Шийдвэр хүргүүлсэн албан тушаалтан
1	Аймгийн Орон нутгийн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 490.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хангай сумын сургуулийн их засварын ажил нь ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй байна.	1	490.10	Албан шаардлага	2025.11.25	524/A0370216	Бус, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
2	Аймгийн 2026 оны төсвийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулаагүй, зураг төсөв батлуулаагүй нийт 1,450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг тусгасан зөрчил илэрлээ.	1	1,450.00	Албан шаардлага	2025.11.25	525/A0370216	Бус, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
3	аймгийн ОНТХО-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 55.5 хувь буюу 5, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт ТАХ-ний 35.7 хувь буюу 5 нийт 10 ТАХ нь аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. /жагсаалтыг хавсаргав/	1	-	Зөвлөмж хүргүүлэх	2025.11.25		
4	Уг аудитаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй 8 ТАХ-г хэрэгжүүлэхээр тусгасан нь төсөл, арга хэмжээний үр нөлөөг бодитой тооцоогүй нь төсөвт өртөг нэмэгдэх, хэрэгжилт удааших эрсдэлийг бий болгож болзошгүй байна.	1	-	Зөвлөмж хүргүүлэх	2025.11.25	131	Аймгийн Засаг дарга
5	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийг жил бүр Засгийн газрын тогтоосон төсвийн хязгаараас хэтрүүлэн төлөвлөсөн байна.	1	-	Зөвлөмж хүргүүлэх	2025.11.25		
Нийт дүн			1,940.1				



АУДИТЫН ШИЙДВЭР



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 525/А.03702/16

Эрдэнэбулган сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу хийсэн "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" гүйцэтгэлийн аудитаар 1,450,000.000 төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн 2026 оны төсвийн орон нутгийн хөгжлийн сангийн 2026 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулаагүй, зураг төсөв батлуулаагүй нийт 1,450,000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг тусгасан зөрчил илэрлээ.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2, 3.1.3-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна", 3.1.4.5-д "холбогдох баримт материал, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар", 3.2.3-т "Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг тавина", 3.2.3.2-т "төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх", 3.2.3.4-т "тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох баримт бичигт үндэслэсэн байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй арга хэмжээнүүдийг төсвийн төсөлд тусгасан зөрчлийг таслан зогсоож, хавсралтад дурдсан төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, эдийн засгийн тооцоолол хийж баталгаажуулсныг баримтаар нотлох арга хэмжээг авч, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 3-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019



2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Батболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА
Г.ЦОГ-ЭРДЭНЭ



Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын
2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар
албан шаардлагын хавсралт

6517143080
АЮА0052 9001034

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний дэлгэрэнгүй жагсаалт (сая төгрөг)						
№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжүүлэх дүн	Ангилал
1	ОНХС	Сангийн толгойн гүүрний засвар (Булган сум)	2026-2026	200.0	200.0	Зам, гүүрний засвар
2		Тээлийн гүүрний засвар (Батцэнгэл сум)	2026-2026	100.0	100.0	Зам, гүүрний засвар
3		Сувилахуйн сургууль тоног төхөөрөмж	2026-2026	200.0	200.0	Тоног төхөөрөмж
4		Ахмадын амралтын тоног төхөөрөмж	2026-2026	200.0	200.0	Тоног төхөөрөмж
5		Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж	2026-2026	500.0	500.0	Тоног төхөөрөмж
6		Нэгдсэн хогийн цэгийг байнгын ажиллагаатай булшлах ажил (Эрдэнэбулган сум)	2026-2026	150.0	150.0	байгууламж
7		Сумын төвийн тохижилт (Цэцэрлэг сум)	2026-2026	100.0	100.0	байгууламж
Нийт дүн				1,450.1	1,450.1	



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 524/А03702/6

Эрдэнэбулган сум

Г Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан бүрэн зохийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасны дагуу хийсэн "Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" гүйцэтгэлийн аудитаар 490,100,000 төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн 2026 оны төсвийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад ажлын даалгавар, зураг төсөв батлуулаагүй 490,100,000 төгрөгийн төсөвт өртөгтэй Хангай сумын сургуулийн их засварын ажлыг тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана", Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан зөрчлийг арилгах арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 01-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга А.Батболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА
Г.ЦОГ-ЭРДЭНЭ

¹ Монгол Улс, Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 65317 баг, Аймгийн ЗДТГ-ын байр, Утас:70333019
АХ А00529001034



Тайлангийн хавсралт №1

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-ний дэлгэрэнгүй жагсаалт (сая төгрөг)						
№	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжүүлэх дүн	Ангилал
1	ОНТХО	Сургуулийн их засвар (Хангай сум)	2026-2026	490.1	490.1	Их засвар
2	ОНХС	Сангийн толгойн гүүрний засвар (Булган сум)	2026-2026	200.0	200.0	Зам, гүүрний засвар
3		Тээлийн гүүрний засвар (Батцэнгэл сум)	2026-2026	100.0	100.0	Зам, гүүрний засвар
4		Сувилахуйн сургууль тоног төхөөрөмж	2026-2026	200.0	200.0	Тоног төхөөрөмж
5		Ахмадын амралтын тоног төхөөрөмж	2026-2026	200.0	200.0	Тоног төхөөрөмж
6		Боловсролын байгууллагын тоног төхөөрөмж	2026-2026	500.0	500.0	Тоног төхөөрөмж
7		Нэгдсэн хогийн цэгийг байнгын ажиллагаатай булшлах ажил (Эрдэнэбулган сум)	2026-2026	150.0	150.0	байгууламж
8		Сумын төвийн тохижилт (Цэцэрлэг сум)	2026-2026	100.0	100.0	байгууламж
Нийт дүн				1,940.1	1,940.1	